МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 04 сарын 20 өдөр Дугаар А/108 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 11 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нислэгийн хөдөлгөөний менежментийн нөөц төлөвлөгөө (Улаанбаатар нислэгийн мэдээллийн бүс)”-г хавсралтаар батлагдсугай.

2.Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллахыг “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК (Э.Энхзориг), төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Э.Төрбаяр)-т тус тус даалгасугай.

САЙД Б.ДЭЛГЭРСАЙХАН

СБТ№ 257890

142630301

Зам, тээврийн сайдын 2026 оны
04 дүгээр сарын 20-ны өдрийн А/108
дугаар тушаалын хавсралт

НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ МЕНЕЖМЕНТИЙН НӨӨЦ ТӨЛӨВЛӨГӨӨ

“УЛААНБААТАР НИСЛЭГИЙН МЭДЭЭЛЛИЙН БҮС”

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ iii

УЛААНБААТАР НИСЛЭГИЙН МЭДЭЭЛЛИЙН БҮСИЙН НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ МЕНЕЖМЕНТИЙН НӨӨЦ ТӨЛӨВЛӨГӨӨ 1

1 ЗОРИЛГО 1

2 НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН НЭГЖ, ТӨВ БА FIR 1

3 НӨӨЦ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОХИЦУУЛАЛТ 2

4 НӨӨЦ НИСЛЭГИЙН ЗАМ БОЛОН НИСЛЭГИЙН ТҮВШНИЙ ЗОХИЦУУЛАЛТ . 4

5 НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ МЕНЕЖМЕНТ БА НӨӨЦ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ 5

6 НИСГЭГЧ БОЛОН АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ 9

7 АГААРЫН ХӨЛГИЙГ АЛБАДАН САЛТУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ 11

Албадан саатуулах дохио 12

8 РАДИО ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ 14

9 АГААРЫН ХӨЛГӨӨС РАДИО НЭВТРҮҮЛГЭЭР ДАМЖУУЛСАН НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭЛЭЛ (TIBA)-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ 14

Нэвтрүүлгийн дэлгэрэнгүй мэдээлэл 15

10 Ашиглах VHF радио холбооны давтамж 15

11 Холбогдох үйл ажиллагааны зохицуулалт 17

12 НИСЭХИЙН ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ 18

13 ЭРЭН ХАЙХ, АВРАН ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 19

ХАВСРАЛТ А – ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ 22

ХАВСРАЛТ Б – НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ МЕНЕЖМЕНТИЙН НӨӨЦ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ОРОЛЦОГЧДЫН ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ 24

ХАВСРАЛТ В – NOTAM МЭДЭЭНИЙ ЗАГВАР 27

ХАВСРАЛТ Г – МОНГОЛ УЛСЫН АГААРЫН ЗАЙД НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ТАСАРСАН ТОХИОЛДОЛД АШИГЛАХ ОЛОН УЛСЫН НИСЛЭГИЙН ЗАМУУД 29

ХАВСРАЛТ Д – НӨӨЦ НИСЛЭГИЙН ЗАМЫН ЗУРАГ 30

ХАВСРАЛТ Е – НӨӨЦ ДАВТАМЖ 31

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 А/108

ӨМНӨХ ҮГ

1.1 Энэхүү нөөц төлөвлөгөөг Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц (цаашид "Конвенц" гэх)-ын Хавсралт 11 "Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ", ICAO-ийн баримт бичиг Doc 9462 "ATS Planning Manual", Doc 9673 "Asia/Pacific Regional Air Navigation Plan" болон Ази, Номхон далайн бүсийн "Asia/Pacific Regional ATM Contingency Plan"-тай тус тус нийцүүлэн боловсруулсан.

1.2 Энэхүү нөөц төлөвлөгөөгөөр цаг агаарын аюултай үзэгдэл, газар хөдлөлт, ажил хаялт, цар тахал эсхүл цэргийн ажиллагаа зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан Улаанбаатар нислэгийн мэдээллийн бүс (цаашид "FIR" гэх)-д нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (цаашид "НХҮ" гэх) тасалдах, ажиллагаагүй болох тохиолдолд олон улсын нислэгийн хөдөлгөөнийг аюулгүй үргэлжлүүлэх талаарх үйл ажиллагааг зохицуулна.

1.3 Энэхүү нөөц төлөвлөгөөг Монгол Улсын агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын Нисэхийн мэдээллийн үйлчилгээ хариуцсан нэгжээр дамжуулан Монгол Улсын Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (цаашид "AIP" гэх)-ээр зарлах ба нөөц төлөвлөгөөний идэвхжилийг боломжтой бол NOTAM мэдээгээр зарлуулна. Хэрэв урьдчилан мэдээлэх боломжгүй бол томилогдсон эрх бүхий байгууллага буюу "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК (цаашид "ИНҮТ" ТӨХХК" гэх) нь хамгийн шуурхай арга замаар идэвхжүүлнэ. Иргэний нисэхийн болон бусад эрх бүхий байгууллага, агаарын тээвэрлэгчид тус нөөц төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бүрэн хамтран ажиллана.

1.4 Энэ төлөвлөгөөнд оруулах аливаа саналыг safety-atc@ncac.mn хаягаар ирүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 A/108

УЛААНБААТАР НИСЛЭГИЙН МЭДЭЭЛЛИЙН БҮСИЙН НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ МЕНЕЖМЕНТИЙН НӨӨЦ ТӨЛӨВЛӨГӨӨ

1 ЗОРИЛГО

1.1 Улаанбаатар FIR-ийн Нислэгийн хөдөлгөөний менежмент (цаашид "НХМ" гэх)-ийн нөөц төлөвлөгөө нь Конвенцын Хавсралт 11 "Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ"-т заасны дагуу Улаанбаатар FIR-д нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ хэсэгчлэн, эсхүл бүрэн тасалдах үед агаарын навигацийн аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг тодорхойлно. НХҮ хэсэгчлэн, эсхүл бүрэн тасалдсан үед Улаанбаатар FIR-д НХҮ-ний үйл ажиллагааг хэрхэн зохицуулах болон агаарын хөлгийн дамжин өнгөрөх нөөц нислэгийн замын мэдээллийг энэхүү төлөвлөгөөгөөр зарлан мэдээлнэ.

1.2 Энэхүү нөөц төлөвлөгөө нь Улаанбаатар FIR-д өнгөрөлтийн нислэг үйлдэх агаарын хөлгийн үйл ажиллагаанд хамаарна. Монгол Улсын нисэх буудлуудаас олон улсын хөөрөлт, буулт үйлдэх болон орон нутгийн нислэг үйлдэх агаарын хөлгийн үйл ажиллагаанд хамаарахгүй.

2 НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН НЭГЖ, ТӨВ БА FIR

2.1 "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал энэхүү нөөц төлөвлөгөөг идэвхжүүлсэн тохиолдолд хөрш FIR-үүдийн НХҮ-ний нэгж болон бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлага (цаашид "НХУ" гэх)-ын төвүүдтэй хийсэн холбогдох харилцан ажиллагааны гэрээ (LOA)-ний дагуу мэдэгдэнэ. Энэхүү нөөц төлөвлөгөө нь доор дурдсан хөрш зэргэлдээх FIR-үүд болон бүсийн НХУ-ын төвүүд (цаашид "АСС" гэх)-д шууд нөлөөлнө:

a) [CHINA]
[BEIJING FIR/ACC]

b) [CHINA]
[HOHHOT FIR/ACC]

c) [CHINA]
[LANZHOU FIR/ACC]

d) [CHINA]
[URUMQI FIR/ACC]

e) [CHINA]
[HARBIN FIR/ACC]

f) [RUSSIA]
[IRKUTSK FIR/ACC]

g) [RUSSIA]

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26.11.08

[KRASNOYARSK FIR/ACC]

h) [RUSSIA]
[NOVOSIBIRSK FIR/ACC]

2.2 Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн болон бусад холбогдох олон улсын байгууллагууд, хөрш зэргэлдээх улсын НХҮ-ний нэгжүүдтэй холбоо барих дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү баримт бичгийн Хавсралт А-д оруулсан. Эдгээр мэдээллийг тогтмол хянан үзэж, холбогдох шинэчилсэн мэдээллийг нэн даруй Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид "ИНЕГ" гэх)-т хүргүүлнэ.

3 НӨӨЦ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОХИЦУУЛАЛТ

3.1 Байгалийн болон бусад хүчин зүйлээс шалтгаалан Улаанбаатар FIR-д НХҮ болон холбогдох дэмжих үйлчилгээ хэсэгчлэн, эсхүл бүрэн тасалдах эрсдэлтэй нөхцөл үүссэн үед энэхүү нөөц төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.2 Улаанбаатар FIR-ийг дамжин өнгөрөх олон улсын өнгөрөлтийн нислэгийн тасралтгүй, аюулгүй байдлыг хангахад хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг энэхүү нөөц төлөвлөгөөнд заасны дагуу зохион байгуулна.

Төв зохицуулах хороо (Central Coordinating Committee /CCC/)

3.3 Төв зохицуулах хороо (цаашид "ТЗХ" гэх) нь нөөц төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан зохицуулах чиг үүрэгтэй бөгөөд НХҮ урт хугацаанд тасалдсан тохиолдолд түр хугацаанд нөөц ажлын байранд шилжүүлэх болон НХҮ-г сэргээх үйл ажиллагааг зохион байгуулна. ТЗХ-ны хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээг "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал тогтоож, тухайн үйл ажиллагаатай уялдуулан оролцох талуудыг Зам, тээврийн сайдад танилцуулна.

ТЗХ нь дараах байгууллагуудын төлөөллөөс бүрдэнэ:

3.3.1 Батлан хамгаалах яам

3.3.2 Зам, тээврийн яам

3.3.3 Тагнуулын ерөнхий газар

3.3.4 Иргэний нисэхийн ерөнхий газар

3.3.5 Онцгой байдлын ерөнхий газар

3.3.6 Цагдаагийн ерөнхий газар

3.3.7 Цаг уур, орчны шинжилгээний газар

3.3.8 Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал

3.3.9 "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК

3.3.10 "Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 A/108

3.3.11 Агаарын тээвэрлэгчдийн төлөөлөл

3.3.12 Бусад шаардлагатай оролцогч талууд

3.4 ТЗХ-ны гишүүдийн холбоо барих мэдээлэл Хавсралт Б-д багтсан.

3.5 ТЗХ нь нөөц төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах бөгөөд НХҮ урт хугацаанд тасалдсан тохиолдолд түр хугацаанд нөөц ажлын байранд шилжүүлэх болон НХҮ-г сэргээх зохион байгуулалтын үйл ажиллагааг хариуцна.

3.6 ИНЕГ-ын дарга шаардлагатай гэж үзвэл Улаанбаатарын FIR-д энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан НХҮ тасалдах нөөц нөхцөл байдал үүсэхээс өмнө, эсхүл үүссэн даруйд нь, хамгийн шуурхай боломжит аргаар (утсаар, эсхүл цахимаар гэх мэт) ТЗХ-г яаралтай хуралдуулна.

Нөөц төлөвлөгөөний үйл ажиллагаа хариуцсан баг (ATM Operational Contingency Group /AOCG/)

3.7 ТЗХ нь НХМ-ийн нөөц төлөвлөгөөний үйл ажиллагаа хариуцсан баг (цаашид "ННТҮАБ" гэх)-ыг хуралдуулах бөгөөд ННТҮАБ-ийн үндсэн чиг үүрэг нь нөөц төлөвлөгөөг идэвхжүүлсэн хугацаанд түүний дагуу явагдах өдөр тутмын үйл ажиллагааг 24 цагийн турш хянах, мөн НХҮ-г тасралтгүй явуулах үйл ажиллагааг зохицуулахад оршино. ННТҮАБ-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээг ТЗХ тогтооно. Шаардлагатай тохиолдолд дараах чиглэлийн мэргэжилтнийг ННТҮАБ-т оролцуулна.

Үүнд:

a) нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (ATS);
b) холбоо, навигаци, ажиглалтын үйлчилгээ (CNS);
c) нисэхийн цаг уурын үйлчилгээ;
d) нисэхийн мэдээллийн үйлчилгээ (AIS);
e) нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент (ATFM).

Тайлбар: Гишүүдийн холбоо барих мэдээлэл Хавсралт Б-д багтсан.

3.8 ННТҮАБ-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах ажил багтана:

a) нөөц төлөвлөгөөг шаардлагатай тохиолдолд хянах, шинэчлэх;
b) нөөц нөхцөл байдлын талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээлэлтэй байх, байнга шинэчилж байх;
c) салбар чиглэл бүрээр нөөц үйл ажиллагааны багийг зохион байгуулах;
d) агаарын зайн хэрэглэгч, холбогдох бүх оролцогч талуудтай тогтмол холбоотой ажиллах;

Тайлбар: Нөөц төлөвлөгөөг идэвхжүүлсэн үед Конвенцын Хавсралт 11-т заасны дагуу ICAO-тай холбогдон ажиллана.

e) хөрш зэргэлдээх НХҮ-ний байгууллагуудтай нөөц үйл ажиллагааны зохицуулалтын талаар хамгийн сүүлийн үеийн мэдээлэл солилцох;

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУЛЬ
Саид Тоонин ... бичгийн
дарцын 26 ... 2008

f) холбогдох байгууллагуудад нөөц нөхцөл байдлын талаар урьдчилан болон яаралтай мэдэгдэх;

g) энэхүү төлөвлөгөөний дагуу, эсхүл нөхцөл байдалд нийцүүлэн NOTAM мэдээ зарлахад шаардлагатай арга хэмжээг авах. Хэрэв нөхцөл байдал урьдчилан тооцоолох боломжтой бол холбогдох NOTAM мэдээг тухайн үйл явдлаас 48 цагийн өмнө гаргана. NOTAM мэдээний загварыг Хавсралт В-д тусгасан. ННТҮАБ нь энэхүү нөөц төлөвлөгөөний дагуу зарлагдах NOTAM мэдээний томилогдсон мэдээлэгч байна.

Төлөвлөгөөний туршилт ба хяналт шинжилгээ

3.9 Энэхүү төлөвлөгөөг хоёр жил тутамд ширээний дасгал, сургуулилт хэлбэрээр, шаардлагатай тохиолдолд утас, эсхүл цахим хурлын аргыг ашиглан туршина.

3.10 Энэхүү төлөвлөгөөг НХУ-ын дадлагажуурт хоёр жил тутамд болон "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал шаардлагатай гэж үзсэн тохиолдол бүрд туршина. Туршилтын үйл ажиллагаанд ИНЕГ-ын зүгээс хяналт тавьж "ИНҮТ" ТӨХХК-аас дараах нэгжүүдийг хамруулан зохион байгуулна.

Үүнд:

- "ИНҮТ" ТӨХХК-ийн Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба
- "ИНҮТ" ТӨХХК-ийн Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын алба
- "ИНҮТ" ТӨХХК-ийн Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба
- "ИНҮТ" ТӨХХК-ийн Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба
- Нислэгийн цаг уурын төв
- Нисэх буудлуудын төлөөлөл
- Агаарын тээвэрлэгчдийн төлөөлөл
- Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал
- Шаардлагатай гэж үзвэл Онцгой байдлын ерөнхий газар

3.11 Энэхүү төлөвлөгөөг 4 жил тутамд бүрэн хянан үзнэ. Төлөвлөгөөнд тусгагдсан агаарын зай, НХҮ-тэй нислэгийн зам, харилцан ажиллагаа болон холбооны мэдээллийг холбогдох хууль тогтоомж, агаарын зайн мэдээлэл, хэрэгжилтийн төлөвлөгөөтэй уялдуулан шинэчилнэ.

3.12 Нөөц төлөвлөгөөг идэвхжүүлсний дараа ННТҮАБ нь хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн талаарх тайланг хэвийн үйл ажиллагааг сэргээснээс хойш 30 хоногийн дотор боловсруулж, "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал болон ИНЕГ-ын даргад хүргүүлнэ. Мөн туршилт зохион байгуулсан тохиолдолд туршилтын үйл ажиллагааны талаарх тайланг гаргаж, "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал болон ИНЕГ-ын даргад хүргүүлнэ.

4 НӨӨЦ НИСЛЭГИЙН ЗАМ БОЛОН НИСЛЭГИЙН ТҮВШНИЙ ЗОХИЦУУЛАЛТ

4.1 Улаанбаатар АСС-ээс үзүүлж буй НХУ-ын үйлчилгээ тасалдсан тохиолдолд нислэгийн аюулгүй байдлыг хангах, тухайн нөхцөлд зохицсон нислэгийн үйл ажиллагааг хязгаарлагдмал байдлаар үргэлжлүүлэх зорилгоор нөөц нислэгийн

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 11/108

замуудыг тогтооно. Нөөц нислэгийн замууд нь одоо мөрдөгдөж буй НХҮ-тэй нислэгийн замуудад тулгуурласан бөгөөд агаарын хөлгийн давхцал үүсэх цэгийг багасгах, мөн НХҮ-г хязгаарлагдмал байдлаар үзүүлж буй үед нэгэн зэрэг үйлдэх нислэгийг хязгаарлах зорилгоор нислэгийн түвшин хуваарилалтын схем (цаашид "FLAS" гэх) ашиглана. Олон улсын нислэгт зориулсан нөөц нислэгийн замыг Хавсралт Г-д тусгасан. Хэрэв цаг агаарын аюултай үзэгдэл зэрэг онцгой нөхцөл тохиолдсон үед ННТҮАБ нь нэмэлт нөөц нислэгийн замыг тухайн үед боловсруулж, NOTAM мэдээгээр нийтэд зарлаж болно. Орон нутгийн нислэг болон хөөрөөгүй байгаа олон улсын нислэгийг нөхцөл байдлын бүрэн үнэлгээ гаргаж, НХҮ-г хангалттай хэмжээнд сэргээх хүртэл, түр хугацаанд цуцална. Энэхүү үйл ажиллагааг зогсоох, эсхүл дахин эхлүүлэх шийдвэрийг ТЗХ гаргана.

4.2 Долоон цаг ба түүнээс дээш хугацааны нислэг мөн тусгай үүргийн нислэгүүд (эрэн хайх, авран туслах, улсын агаарын хөлөг, хүмүүнлэгийн нислэг гэх мэт) нь FL290 ба түүнээс дээш нислэгийн түвшинд нислэг үйлдэх давуу эрх эдэлнэ.

4.3 Монгол Улсын нисэх буудлуудын бүх нислэгийн үйл ажиллагаа зогссон тохиолдолд тухайн нисэх буудлын захиргаанаас олон улсын нислэг үйлддэг агаарын тээвэрлэгчдэд үйл ажиллагааг дахин эхлүүлэх үеийн болон нислэгийн төлөвлөлтийн мэдээллийн талаар мэдэгдэнэ. Ийм мэдээлэл хүлээн авсан олон улсын нислэгүүд нь орон нутгийн нислэгийн замаар олон улсын нөөц нислэгийн замд нэгдэх нислэгийн төлөвлөгөө гаргах шаардлага үүсэх магадлалтай.

4.4 Олон улсын нислэг үйлддэг агаарын тээвэрлэгчид Монгол Улсын агаарын зайг дайран өнгөрөлгүйгээр Улаанбаатар FIR-ийн баруун талаар тойрон ОХУ болон БНХАУ-ын FIR-ээр дамжин нислэг үйлдэх боломжтой. Энэ тохиолдолд ашиглах нөөц нислэгийн замуудыг тухайн улсын НХҮ хариуцсан эрх бүхий байгууллагууд тодорхойлно.

5 НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ МЕНЕЖМЕНТ БА НӨӨЦ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

Хязгаарлагдмал Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ болон Нислэгийн мэдээллийн үйлчилгээ (FIS)

5.1 Нөөц төлөвлөгөөнд шилжсэн үед НХУ-ын үйлчилгээ үзүүлэх боломжгүй тохиолдолд, ялангуяа холбоо тасалдсан болон НХУ-ын ажиглалтын үйлчилгээний үзүүлэх боломжгүй нөхцөлд холбогдох мэдээллийг багтаасан NOTAM мэдээг зарлана.

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний үүрэг, хариуцлага

5.2 НХҮ тасалдах нөөц нөхцөл байдлын эхний үе шатуудад НХУ-ын ачаалал ихсэж болзошгүй бөгөөд агаарын хөлгийг өөр нислэгийн замд оруулах тактикийн арга хэмжээний талаар энэхүү төлөвлөгөөнд ороогүй.

5.3 Улаанбаатар FIR-д НХҮ үзүүлэх боломжгүй болсон тохиолдолд дараах мэдээллийг агуулсан NOTAM мэдээ зарлана:

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 А/108

a) нөөц арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх огноо, цаг;
b) буулт үйлдэх ба өнгөрөлтийн нислэг үйлдэх агаарын зай болон нислэг үйлдэхээс зайлсхийх агаарын зай;
c) үзүүлэх боломжтой, эсхүл боломжгүй үйлчилгээ, ажиллагаатай, эсхүл ажиллагаагүй тоног төхөөрөмж, НХҮ үзүүлэхэд тулгарсан аливаа хязгаарлалтууд (бүс, ойртолт, аэродромын НХУ, нислэгийн мэдээллийн үйлчилгээ гэх мэт)-ын талаар дэлгэрэнгүй мэдээллийг, үйлчилгээ сэргээхээр төлөвлөсөн хугацааны (мэдэгдэж буй тохиолдолд) хамт;
d) бусад орлуулах үйлчилгээний тухай мэдээлэл;
e) ашиглагдах НХҮ-тэй нислэгийн замууд, AIP-аар нийтлэгдсэн нөөц нислэгийн замууд, эсхүл тактикийн түвшинд тогтоосон нөөц нислэгийн замууд;
f) хөрш зэргэлдээх НХҮ-ний нэгжүүдийн дагаж мөрдөх, энэхүү төлөвлөгөөнд тусгагдаагүй тусгай журмууд;
g) нисгэгчдийн дагаж мөрдөх тусгай журмууд;
h) үйлчилгээ зогсох үед дагаж мөрдөх бусад шаардлагууд болон агаарын тээвэрлэгчдэд шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллүүд.

5.4 NOTAM мэдээний загварыг Хавсралт В-д багтаасан.

5.5 Монгол Улсын олон улсын NOTAM мэдээ хариуцсан нэгж нь NOTAM мэдээ зарлах боломжгүй тохиолдолд, ИНЕГ, эсхүл эрх олгосон байгууллагаас "www.ais.mn" цахим хуудсаар дамжуулан NOTAM мэдээ зарлах арга хэмжээ авна.

Нислэгийн төлөвлөгөө

5.6 Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь нөөц төлөвлөгөө болон түүнийг идэвхжүүлэх хугацаатай танилцсан байх үүрэгтэй. Энэхүү нөөц төлөвлөгөө идэвхэжсэн үед тухайн бүсэд нислэг үйлдэхээр төлөвлөсөн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь нөөц төлөвлөгөөний шаардлагад нийцүүлэн тухайн агаарын хөлгийн нислэгийг төлөвлөх шаардлагатай.

5.7 Нөөц төлөвлөгөө идэвхэжсэн байх хугацаанд нислэгийн төлөвлөгөөтэй холбоотой үйл ажиллагаа нь Конвенцын Хавсралт 2-ын 3-р бүлэг, ICAO-ийн баримт бичиг Doc 4444, Chapter 4 болон Appendix 2-т заасан шаардлагын дагуу явагдана. Гэсэн хэдий ч, нөөц төлөвлөгөө идэвхэжсэн агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлгийн талаарх нэмэлт мэдээлэл шаардагдаж болно.

5.8 Нөөц төлөвлөгөө идэвхэжсэн үед Давтагддаг нислэгийн төлөвлөгөө (RPL)-г зөвшөөрөхгүй. Иймд агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчид нислэгийн төлөвлөгөөг нөөц төлөвлөгөөний зохицуулалтад нийцүүлэн илгээх шаардлагатай.

Агаарын хөлгийн зайчлал

5.9 Шаардлагатай тохиолдолд ICAO-ийн баримт бичиг Doc 4444 "Procedures for Air Navigation Services - Air Traffic Management" (PANS-ATM) болон Doc 7030

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 11/103

"Regional Supplementary Procedures"-т заасан зайчлалын шалгуурыг баримтална.

5.10 Хамгийн бага тууш зайчлал нь 15 минут байх хэдий ч холбогдох харилцан ажиллагааны гэрээ эсхүл бусад нөөц хэлэлцээрээр зөвшөөрсний дагуу, мөн Мах тооны аргачлалын дагуу 10 минут болгон багасгаж болно.

5.11 Нөөц нислэгийн зам хоорондын хажуугийн зайчлал 100 NM-аас багагүй байна. 100 NM-аас бага, мөн огтлолцох замын хувьд нислэгийн түвшин FL410 хүртэл 1,000 ft, FL410-аас дээш 2,000 ft босоо зайчлал тогтоогдоно.

Нислэгийн түвшин олгох давуу эрх

5.12 FLAS-ийн дагуу нислэгийн түвшин олгохдоо боломжтой тохиолдолд нислэгийн үргэлжлэх хугацаа 6-7 цаг буюу түүнээс дээш хугацааны нислэг үйлдэж буй агаарын хөлгүүдэд давуу эрх олгоно.

Агаарын зайн ангилал

5.13 Үйлчилгээ зогссон үеийн нөхцөл байдал, түвшнээс шалтгаалан агаарын зайн ангилал өөрчлөгдөх боломжтой. Тус өөрчлөлтийг NOTAM мэдээгээр зарлан, мэдээлнэ.

Агаарын хөлөг байрлалаа илтгэх

5.14 Агаар-газрын үндсэн холбоо нь VHF байна.

5.15 Улаанбаатар FIR-д зөвхөн НХҮ болон НХУ-ын холбооны хэвийн үйл ажиллагаа үзүүлэх боломжгүй болсон тохиолдолд агаарын хөлгөөс Радио нэвтрүүлгээр дамжуулсан нислэгийн хөдөлгөөний мэдээлэл (цаашид "TIBA" гэх)-ийн үйл ажиллагааны зохицуулалт хэрэгжинэ. TIBA-ийн үйл ажиллагааны зохицуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон холбооны шаардлага Конвенцын Хавсралт 11-ийн Attachment B-д тусгагдсан.

5.16 TIBA-ийн давтамжууд дараах байдалтай байна:

-	AB /Алтай, Баян сектор/	-	126.3 Мгц
-	MCE /Мөрөн, Төв сектор/	-	135.3 Мгц
-	GDR /Говь, Дорнод сектор/	-	128.4 Мгц

Хязгаарлалт

5.17 Түргэний нислэг, Эрэн хайх, авран туслах (цаашид "SAR" гэх) нислэг, хүмүүнлэгийн нислэг, ИНЕГ-ын даргын зөвшөөрсөн бусад зайлшгүй нислэг болон ННҮАБ-аас зааварласнаас бусад тохиолдолд Улаанбаатар FIR-д нөөц төлөвлөгөөг идэвхжүүлсэн байх хугацаанд Ил харааны нислэгийн дүрмээр үйлдэгдэх /VFR/ нислэг, улсын агаарын хөлгийн нислэг, цагийн хуваарийн бус нислэг үйлдэхийг хориглоно.

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Тэрбиш ... албан бичгийн
Дагалдах 26 ш 11/108 ... хуудас

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагаа

5.18 НХҮ үзүүлж буй нэгжүүд өөрийн нэгжийн онцгой нөхцөлийн үед ажиллах журмыг мөрдөн, харилцан ажиллагааны гэрээний дагуу нөөц журмын зохих түвшнийг идэвхжүүлнэ. Үүнд:

a) гэнэтийн нөхцөл байдлаас шалтгаалан Улаанбаатар ACC-ээс үзүүлэх НХҮ тасалдах, зогсох тохиолдолд нислэгийн хөдөлгөөний удирдагч нь нисгэгчдэд онцгой нөхцөл байдлын талаар мэдээлж, бүсийн НХУ-ын төвийг нүүлгэн шилжүүлэх болон НХҮ зогсох боломжтойг анхааруулна. Хэрэв нүүлгэн шилжүүлэх шаардлага гарвал нүүлгэн шилжүүлэх тухай холбогдох журмыг хэрэгжүүлж, боломжтой бол ашиглаж буй радио давтамжаар нисгэгчдэд нөөц холбооны хэрэгсэл ашиглах зааврыг дамжуулна;

b) нөөц үйл ажиллагаа идэвхэжсэн үед агаарын тээвэрлэгчид нислэгийн төлөвлөгөө болон НХҮ-нд холбогдолтой бусад мэдээг Улаанбаатар ACC рүү AMHS сүлжээгээр явуулсан хэвээр байна;

c) "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын мэдэгдлээр хөрш зэргэлдээх FIR-ийн ACC (Иркутск, Красноярск, Новосибирск, Өрөмч, Ланжоу, Бээжин, Хөх хот, Хайлар) хооронд байгуулсан харилцан ажиллагааны гэрээний дагуу нөөц журмыг идэвхжүүлнэ;

d) нөөц үйл ажиллагаа идэвхэжсэн үед Улаанбаатар FIR-д нэвтрэхээс өмнө ИНЕГ-аас урьдчилан зөвшөөрөл авах бөгөөд нисэх баг нь хөрш зэргэлдээх НХҮ хариуцсан эрх бүхий байгууллагаас олгосон НХУ-ын зөвшөөрөл, нислэгийн зам, нислэгийн түвшин, холбооны зааврыг дагаж мөрдөнө;

e) Улаанбаатар FIR-д нэвтрэх агаарын хөлгийн хилийн тооцоот цаг, нислэгийн түвшний тухай мэдээллийг хөрш зэргэлдээх НХҮ хариуцсан эрх бүхий байгууллагатай энэхүү төлөвлөгөөний дагуу зөвшилцөнө;

f) хөрш зэргэлдээх ACC-ээс Улаанбаатар FIR-д нэвтрэх агаарын хөлөгт Улаанбаатар FIR-д нислэг үйлдэх бүхий л хугацаанд хамгийн сүүлд олгогдсон нислэгийн түвшин, хурд (Mach тоо)-ыг хадгалах захирамж өгнө;

g) Улаанбаатар FIR-ийн НХҮ-ний нэгж зөвшөөрсөн, эсхүл энэхүү нөөц төлөвлөгөөнд зааснаас бусад тохиолдолд хөрш зэргэлдээх ACC-ээс Улаанбаатар FIR-д нэвтрэх агаарын хөлгийн нислэгийн зам, нислэгийн түвшин, хурдыг өөрчлөхгүй;

h) хөрш зэргэлдээх бүсийн НХУ-ын төв нь Улаанбаатар FIR-д нэвтрэх агаарын хөлгийг Улаанбаатарын FIR-ийг дамжин өнгөрсний дараа, дараагийн FIR-д нэвтрэн орох тооцоот цагаас 10-аас багагүй минутын өмнө тухайн FIR-ийн НХҮ-ний нэгжтэй холбоо тогтоосон байх шаардлагатайг мэдэгдэнэ;

i) нисэх баг нь Монгол Улсын агаарын зайг тойрч нисэх сонголт хийж болох бөгөөд энэ тохиолдолд зарлагдсан НХҮ-тэй нислэгийн зам, эсхүл хөрш

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Тушаал зөвшөөрсөн тухай
Дугаар 26 А/108 Улаанбаатар хот

зэргэлдээх FIR-ийн эрх бүхий байгууллагаас NOTAM мэдээгээр зарласан нөөц нислэгийн замуудыг ашиглана.

Нөөц үйл ажиллагаанд шилжих

5.19 Агаарын зай хаагдах магадлалтай тодорхойгүй нөхцөл үүссэн үед агаарын тээвэрлэгчид нислэгийн явцад нислэгийн зам өөрчлөгдөх боломжтойд бэлэн байх, мөн энэхүү төлөвлөгөөнд заасан болон тухайн улсаас NOTAM, эсхүл AIP-аар зарлаж болох нөөц нислэгийн замтай танилцсан байх ёстой.

5.20 Урьдчилан зарлаагүйгээр агаарын зай хаагдсан тохиолдолд нислэгийн хөдөлгөөний удирдагч нь боломжтой бол өөрийн хариуцлагын бүсэд нислэг үйлдэж буй бүх агаарын хөлөгт агаарын зайг хаасан талаар болон дараагийн зааварчилгааг хүлээхийг мэдэгдэнэ.

5.21 Агаарын зай эсхүл нисэх буудал хаагдсан тухай зарлагдсан үед агаарын тээвэрлэгч бүр өөрийн компанийн журмаар өөр нислэгийн зам сонгож болох тул нислэгийн хөдөлгөөний удирдагч нь нисэх багийн хүсэлтэд шуурхай хариу өгч, аюулгүй байдлыг ханган ажиллана.

Удирдлага шилжүүлэх ба зөвшилцөл хийх

5.22 Энэхүү нөөц төлөвлөгөө, эсхүл харилцан ажиллагааны гэрээнд өөрөөр заагаагүй бол удирдлага шилжүүлэх болон холбооны үйл ажиллагааг НХҮ-ний нэгжүүд хоорондын FIR-ийн хил буюу удирдлага шилжүүлэх цэг дээр гүйцэтгэнэ.

6 НИСГЭГЧ БОЛОН АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

6.1 Нөөц үйл ажиллагааны үед НХУ-аас зааварчилсан, эсхүл нөөц нислэгийн зам болон FLAS-д өөрчлөлт орсон тухай NOTAM мэдээгээр зарласнаас бусад тохиолдолд Монгол Улсын AIP-д заасан нислэгийн төлөвлөгөө ирүүлэх шаардлага нь хүчинтэй хэвээр байна.

Өнгөрөлтийн нислэгийн зөвшөөрөл

6.2 Агаарын тээвэрлэгчид нь Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх зөвшөөрлийг Монгол Улсын ИНЕГ-аас авна. Нөөц төлөвлөгөө идэвхэжсэн үед хөрш зэргэлдээх НХҮ-ний эрх бүхий байгууллага нь Улаанбаатар FIR-д нислэг үйлдэх агаарын хөлөгт өнгөрөлтийн нислэгийн зөвшөөрөл олгох, эсхүл зөвшилцөл хийх үүрэг хүлээхгүй. Харин агаарын тээвэрлэгчид нь Улаанбаатар FIR-д нислэг үйлдэхэд шаардлагатай өнгөрөлтийн нислэгийн зөвшөөрлийг авсан байх үүрэгтэй.

Холбоо, навигаци, ажиглалтын (CNS) чадамж

6.3 Улаанбаатар FIR-д нислэг үйлдэх агаарын хөлгүүд дор дурдсан холбоо, навигаци, ажиглалтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх шаардлагатай:

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26.11/108

a) VHF радио холбооны төхөөрөмж – хоёр талын холбоо;
b) Өндрийн түвшний даралт мэдээлэгч транспондер;
c) агаарт мөргөлдөхөөс сэргийлэх систем (ACAS II);
d) ослын байршил дамжуулагч (ELT).

Нисэх багийн үйл ажиллагаа

6.4 Нисэх баг нь агаарын хөлгийн байрлал илтгэх хэвийн журмын дагуу нислэгийн хөдөлгөөний удирдагчид байрлалаа тогтмол илтгэнэ.

6.5 Нөөц үйл ажиллагаа идэвхэжсэн үед Улаанбаатарын FIR-д нислэг үйлдэж буй агаарын хөлгийн нисэх баг нь дараах журмыг мөрдөнө:

a) энэхүү нөөц төлөвлөгөөнд тусгагдсан НХҮ-тэй нислэгийн замаар нислэг үйлдэх бүх агаарын хөлөг хэрэглэлийн нислэгийн дүрэм (IFR)-ийг баримтална. Мөн FLAS-ийг баримтлан Хавсралт Д-д заасан нислэгийн замуудын өндрийн хязгаарлалтын дагуу нислэг үйлдэнэ.
b) нисэн гарах болон нисэн очих аэродромоос хамааран Хавсралт Д-д заасан нөөц нислэгийн замыг ашиглан нислэгийн төлөвлөгөө гаргана.
c) агаарын хөлөг нь тухайн нислэг үйлдэж буй нөөц нислэгийн замын гол тэнхлэгийн дагуу аль болох ойр ниснэ.
d) нисэх баг нь Хавсралт Е-д заасан нөөц давтамжийг байнга сонсоно.
e) нисэх баг нь агаарын хөлгийн байрлал болон бусад шаардлагатай мэдээллийг Хавсралт 3-д заасан TIBA үйл ажиллагааны зохицуулалтын дагуу дамжуулна.
f) агаарын хөлөг нь навигацийн болон мөргөлдөхөөс сэргийлэх гэрлийг асаасан байна.
g) онцгой нөхцөл, эсхүл нислэгийн аюулгүй байдалтай холбоотой авах арга хэмжээнээс бусад үед нисэх баг нь Улаанбаатар FIR-д нислэг үйлдэх бүхий л нислэгийн туршид сүүлд олгогдсон нислэгийн түвшин, Mach тоо, SSR кодыг өөрчлөхгүй. Хэрэв код олгогдоогүй бол 2000 кодыг ашиглана.
h) нисэх баг нь Улаанбаатар FIR-д нэвтрэн орохоос 10 минутаас багагүй хугацааны өмнө эсхүл хөрш зэргэлдээх НХУ-ын нэгжтэй байгуулсан харилцан ажиллагааны гэрээ эсхүл нөөц үйл ажиллагааны бусад хэлэлцээрийн дагуу тогтоогдсон хугацаанаас багагүй хугацааны өмнө зөвшөөрөгдсөн нислэгийн өндрөө эзэлсэн байх шаардлагатай.
i) нисэх баг нь Улаанбаатар FIR-д нэвтрэхээс өмнө агаарын хөлгийн хамгийн сүүлийн байрлалын мэдээллийг Улаанбаатар FIR-д орох цэгийн тооцоот цаг, удирдлага шилжүүлэх цэгийн тооцоот цаг болон Улаанбаатар FIR-ээс гарах цэгийн тооцоот цагуудын хамт мэдээлнэ.
j) Улаанбаатар FIR-ээс гарах тооцоот цагаас ямар ч тохиолдолд 10 минутаас багагүй хугацааны өмнө дараагийн НХУ-ын нэгжтэй холбоо тогтоосон байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сая гарын үсэг зурсан
Лавлах 26 А/108

k) нисэх баг нь Хавсралт 3-д заасан VHF, HF давтамжууд дээр ICAO-ын TIBA үйл ажиллагааны зохицуулалтыг дагаж мөрдөнө. Нисэх баг нь онцгой нөхцөл, эсхүл нислэгийн аюулгүй байдалтай холбоотойгоор өндөр авч, алдах, эсхүл зөвшөөрсөн нөөц нислэгийн замаас хазайх болон тухайн үеийн нөхцөл байдлын талаар дээрх давтамжууд дээр харанхуй нэвтрүүлэг хийнэ.

l) Улаанбаатар FIR-ийг дамжин өнгөрөх нислэгүүд нь онцгой нөхцөл, эсхүл нислэгийн аюулгүй байдлыг хангах шаардлагын улмаас зөвшөөрөгдсөн нислэгийн түвшнийг хадгалах боломжгүй болсон үед нөөц нислэгийн замын гол тэнхлэгийн баруун талд өндөр авах эсхүл өндөр алдах үйлдлийг гүйцэтгэнэ. Хэрэв Улаанбаатар FIR-ээс хазайх буюу тойрч нисэх тохиолдолд нисэх баг нь энэ тухайгаа холбогдох агаарын зайг хариуцаж буй ACC-д яаралтай мэдэгдэнэ. Нисэх баг нь нислэгийн явцад өндрөө өөрчлөх тохиолдолд агаарын хөлгийн таних дугаар, байрлал, нислэгийн зам, өндрийн мэдээлэл (чөлөөлсөн, огтолсон, авч буй болон хадгалж буй нислэгийн түвшин)-ийг 121.5 Мгц давтамж дээр дамжуулна.

m) нисэх баг нь нислэгийн ижил түвшинд нисэж буй эхний агаарын хөлгөөс 15 минутын тууш зайчлал хангасан байх үүрэгтэй.

Энэхүү нөөц төлөвлөгөө нь нислэгийн үйл ажиллагаанд гарч болох бүх нөхцөл, тохиолдлуудыг тусгаагүй байж болох тул нисэх баг нь нөөц төлөвлөгөө идэвхэжсэн үед нөөц агаарын зайд нислэг үйлдэх хугацаандаа өндөр сонор сэрэмжтэй байж, нислэгийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой бүхий л арга хэмжээг авч ажиллахад бэлэн байх шаардлагатай.

7 АГААРЫН ХӨЛГИЙГ АЛБАДАН СААТУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

Иргэний агаарын хөлгийг албадан саатуулах

7.1 Нөөц нислэгийн замаар нислэг үйлдэх нь агаарын хөлгийг нислэгийн хэвийн урсгалаас гажихад хүргэх тул цэргийн агаарын хөлөг албадан саатуулах магадлалтайг нисэх багийн зүгээс мэдэж байх үүрэгтэй. Иймд агаарын тээвэрлэгчид Конвенцын Хавсралт 2 "Rules of the Air"-ын 3.8 болон Appendix 2-ын Section 2, 3-т заасан олон улсын албадан саатуулах үйл ажиллагааны зохицуулалттай танилцсан байх ёстой.

7.2 Нисэх баг нь албадан саатуулж буй агаарын хөлгөөс өгсөн зааварчилгааг дагаж мөрдөнө. Энэ тохиолдолд албадан саатуулагдаж буй агаарын хөлгийн нисэх баг нь тухайн нөхцөл байдлын талаар радио холбоогоор мэдээлнэ.

7.3 Улаанбаатар FIR-ийг хаах болон нөөц нислэгийн зам ашиглах боломжгүй нөхцөл байдал үүссэн үед Улаанбаатар FIR-д нислэг үйлдэхээс зайлсхийх шаардлагатай. Монгол Улсын агаарын зай бүрэн хаагдсан тохиолдолд НХҮ-ний эрх бүхий байгууллагаас боломжит бүх аргаар энэ мэдээллийг тараана.

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид 26 А/108

7.4 Нисгэгч нь онцгой нөхцөлийн 121.5 Мгц давтамжийг байнга сонсох бөгөөд агаарын хөлөг ажиглалтын хоёрдогч радарын бүрхэлтэд байгаа эсэхээс үл хамааран нислэгийн явцад транспондерыг байнга ажиллуулна. Транспондерыг нислэгийн хөдөлгөөний удирдагчаас олгосон автомат хариулагчийн код (дискрет код) дээр тохируулах эсхүл код олгогдоогүй бол 2000 кодыг сонгож тохируулна.

Албадан саатуулах дохио

7.5 Албадан саатуулагдсан агаарын хөлөг нь нэн даруй дараах арга хэмжээг авна:

a) ил харагны дохиог Конвенцын Хавсралт 2-ын Appendix 1-т заасан утгаар тайлж, ойлгон, албадан саатуулж буй агаарын хөлгөөс өгсөн зааварчилгааг дагаж мөрдөнө;
b) боломжтой бол холбогдох НХҮ-ний нэгжид нэн даруй мэдэгдэнэ;
c) онцгой нөхцөлийн 121.5 МГц давтамж дээр ерөнхий дуудлага хийж, албадан саатуулагдсан агаарын хөлгийн дуудлага, мөн нислэгийн шинж чанарын талаар мэдээлэл өгч, албадан саатуулж буй агаарын хөлөг, эсхүл албадан саатуулах удирдлагын холбогдох нэгжтэй радио холбоо тогтоохыг оролдоно; хэрэв холбоо тогтоогдоогүй бөгөөд боломжтой бол уг дуудлагыг онцгой нөхцөлийн 243 МГц давтамж дээр давтан хийнэ;
d) SSR транспондертой бол, холбогдох НХҮ-ний нэгжээс өөрөөр захирамж өгөөгүй тохиолдолд, Mode A, автомат хариулагчийн код 7700-г сонгож тохируулна.

7.6 Хэрэв ямар нэг эх сурвалжаас радио холбоогоор хүлээн авсан зааварчилгаа нь албадан саатуулж буй агаарын хөлгөөс ил харагны дохиогоор өгсөн зааварчилгаатай зөрчилдвөл, албадан саатуулагдсан агаарын хөлөг нь албадан саатуулж буй агаарын хөлгөөс өгсөн ил харагны зааварчилгааг мөрдсөөр байх бөгөөд нэн даруй тодруулга хүснэ.

7.7 Хэрэв ямар нэг эх сурвалжаас радио холбоогоор хүлээн авсан зааварчилгаа нь албадан саатуулж буй агаарын хөлгөөс радио холбоогоор өгсөн зааварчилгаатай зөрчилдвөл, албадан саатуулагдсан агаарын хөлөг нь албадан саатуулж буй агаарын хөлгөөс радио холбоогоор өгсөн зааварчилгааг мөрдсөөр байх бөгөөд нэн даруй тодруулга хүснэ.

7.8 Албадан саатуулах үеийн радио холбоо - Албадан саатуулах явцад радио холбоо тогтоогдсон боловч энгийн яриагаар харилцах боломжгүй тохиолдолд, дараах хүснэгтэд заасан загварчилсан хэллэг болон дуудлагын авиаг ашиглан захирамжийг дамжуулах, захирамж болон онцгой мэдээллийг хүлээн авснаа илэрхийлэхийг оролдох бөгөөд хэллэг бүрийг хоёр удаа давтан дамжуулна.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 11/08

7.9 Албадан саатуулах үеийн загварчилсан хэллэг болон дуудлагын авиа

АЛБАДАН САТУУЛЖ БУЙ агаарын хөлгийн ашиглах загварчилсан хэллэг	АЛБАДАН САТУУЛАГДАЖ БУЙ агаарын хөлгийн ашиглах загварчилсан хэллэг
CALL SIGN KOL SA-IN What is your call sign?	CALL SIGN KOL SA-IN My call sign is (call sign)
FOLLOW FOL-LO Follow me	WILCO VILL-KO Understood Will comply
DESCEND DEE-SEND Descend for landing	CAN NOT KANN NOTT Unable to comply
YOU LAND YOU LAAND Land at this aerodrome	REPEAT REE-PEET Repeat your instruction
PROCEED PRO-SEED You may proceed	AM LOST AM LOST Position unknown MAYDAY MAYDAY I am in distress HI-JACK I have been hijacked LAND LAAND I request to land at (place name) DESCEND DEE-SEND I require descent

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Дугаар 26 11/108

8 РАДИО ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

Холбооны үйлчилгээ доголдох - Нисгэгчийн радио холбооны үйл ажиллагаа

8.1 Улаанбаатар FIR-д нөөц үйл ажиллагааны үед нислэг үйлдэж буй нисэх баг нь НХҮ үзүүлж буй газруудад радио холбооны ердийн журмыг баримтална. Харин НХҮ хязгаарлагдмал эсхүл тасалдсан тохиолдолд энэхүү нөөц төлөвлөгөөнд заагдсан зохицуулалт, эсхүл NOTAM мэдээгээр зарлагдсан журмын дагуу холбоо тогтооно.

8.2 НХҮ үзүүлдэг үндсэн давтамжууд дээр холбоо гэнэт алдагдвал нисгэгч нь дараагийн боломжит давтамжуудыг дарааллын дагуу ашиглах хэрэгтэй. Жишээлбэл, өнгөрөлтийн нислэгийн үед холбоо тасарвал дараагийн холбоо барих давтамж нь дараагийн удирдлага шилжүүлэх давтамж байна. Мөн нисгэгч нь хамгийн сүүлд хоёр талын холбоотой байсан давтамж дээр дахин холбоо тогтоох оролдлого хийх шаардлагатай. Хэрэв нислэгийн хөдөлгөөний удирдагчтай холбоо тогтоох боломжгүй тохиолдолд нисгэгч нь заагдсан давтамж дээр байрлалаа үргэлжлүүлэн илтгэх бөгөөд TIBA үйл ажиллагааны зохицуулалтын дагуу байрлалаа илтгэх үүрэгтэй.

Холбооны давтамжууд

8.3 Улаанбаатар FIR-д нислэгийн мэдээллийн үйлчилгээ (FIS) үзүүлж буй НХҮ-ний нэгжүүд, нөөц нислэгийн зам болон Улаанбаатар FIR-ийн агаар-газрын холбоог хянахад ашиглах давтамжуудын жагсаалтыг Хавсралт Е-д дэлгэрэнгүй тусгасан.

9 АГААРЫН ХӨЛГӨӨС РАДИО НЭВТРҮҮЛГЭЭР ДАМЖУУЛСАН НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭЛЭЛ(TIBA)-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

Танилцуулга ба нэвтрүүлгийн хэрэглээ

9.1 Агаарын хөлгөөс дамжуулсан нислэгийн хөдөлгөөний мэдээлэл нь нисгэгчдийн зүгээс зөвлөмжийн шинжтэй илтгэлүүд болон холбогдох нэмэлт мэдээллийг тогтоогдсон VHF радио холбооны давтамж дээр дамжуулж, ойр орчимд нислэг үйлдэж буй бусад агаарын хөлгийн нисгэгчдэд мэдээлэл өгөх зорилготой.

9.2 TIBA-г зөвхөн шаардлагатай тохиолдолд нэвтрүүлэх ба түр хугацааны арга хэмжээ болгон ашиглана.

9.3 Дараах нөхцөлд тогтоосон агаарын зайд энэхүү нэвтрүүлгийн зохицуулалтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

a) хяналттай агаарын зайгаас гадуур нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний зүгээс олгож буй мөргөлдөх аюулын талаарх мэдээллийг нэмэлтээр хангах шаардлага үүссэн; эсхүл
b) нислэгийн хөдөлгөөний хэвийн үйлчилгээ түр хугацаанд тасалдсан.

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн ... Онцгой ...
Дэлгэц 26.11.08 ... ...

9.4 Ийм агаарын зайг тухайн агаарын зайд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэх хариуцлага хүлээсэн Улс (эсхүл Улсууд) тодорхойлж, шаардлагатай тохиолдолд ICAO-ийн холбогдох Бүсийн төв(үүд)-ийн дэмжлэгтэйгээр AIP эсхүл NOTAM-аар албан ёсоор зарлана. Үүнд ашиглах VHF радио холбооны давтамж, мэдээ дамжуулах формат, мөн мөрдөх зохицуулалтыг хамтад нь тусгана. 1.3 а)-д заасан нөхцөлд хоёр буюу түүнээс дээш Улс хамрагдаж байвал, тухайн агаарын зайг бүс нутгийн агаарын навигацийн хэлэлцээрийн үндсэн дээр тогтоож, ICAO-ийн баримт бичиг Doc 7030-д нийтэлнэ.

9.5 Тогтоосон агаарын зайг байгуулахдаа түүний хэрэглээний зохистой байдлыг 12 сараас илүүгүй хугацааны давтамжтайгаар хянах огноонуудыг холбогдох НХҮ-ний эрх бүхий байгууллага(ууд) урьдчилан тохиролцоно.

Нэвтрүүлгийн дэлгэрэнгүй мэдээлэл

10 Ашиглах VHF радио холбооны давтамж

10.1 Ашиглах VHF радио холбооны давтамжийг бүс нутгийн түвшинд тогтоож, албан ёсоор зарлана. Гэвч хяналттай агаарын зайд нислэгийн хөдөлгөөний хэвийн үйлчилгээ түр хугацаанд тасалдсан тохиолдолд, холбогдох Улсууд тухайн агаарын зайд ашиглах VHF радио холбооны давтамжаар, уг агаарын зайд нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэхэд хэвийн ашигладаг давтамжийг түр хугацаанд зарлаж болно.

10.2 НХҮ-ний агаар-газрын радио холбоонд VHF ашиглагдаж байгаа ба агаарын хөлөг ажиллагаатай хоёр л VHF төхөөрөмжтэй тохиолдолд нэгийг нь холбогдох НХҮ-ний давтамжид, нөгөөг нь ТІВА-ийн давтамжид тус тус тааруулна.

10.3 Радио холбоог сонсож, хянах

Тогтоосон агаарын зайд нэвтрэхээс 10 минутын өмнөөс, уг агаарын зайгаас нисэн гарах хүртэл ТІВА-ийн давтамжийг сонсож, тогтмол хянана. Тогтоосон агаарын зайн хажуугийн хязгаарын дотор байрлах аэродромоос хөөрч буй агаарын хөлгийн хувьд, хөөрөлтийн дараах боломжит хамгийн ойрын мөчөөс эхлэн тус давтамжийг сонсож, уг агаарын зайгаас гарах хүртэл тухайн давтамжийг хянана.

10.4 Нэвтрүүлэг хийх цаг хугацаа

Дараах тохиолдлуудад нэвтрүүлэг хийнэ. Үүнд:

a) тогтоосон агаарын зайд нэвтрэхээс 10 минутын өмнө, эсхүл тогтоосон агаарын зайн хажуугийн хязгаарын дотор байрлах аэродромоос хөөрч буй нисгэгчийн хувьд хөөрөлтийн дараах боломжит хамгийн ойрын мөчид;
b) илтгэх цэгийг дайран өнгөрөхөөс 10 минутын өмнө;

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Тушин ... Онцгой ...
Дэлгэрэнгүй ... Хүчинтэй
26.11.08

c) НХУ-тэй нислэгийн замыг огтлох, эсхүл түүнд нэгдэхээс 10 минутын өмнө;
d) алслагдсан илтгэх цэгүүдийн хооронд 20 минут тутамд;
e) боломжтой тохиолдолд, нислэгийн түвшин өөрчлөхөөс 2–5 минутын өмнө;
f) нислэгийн түвшин өөрчлөх үед;
g) нисгэгч шаардлагатай гэж үзсэн бусад үед.

10.5 Нэвтрүүлгийн хэлбэр

10.5.1 Нислэгийн түвшин өөрчлөгдөж буйг илэрхийлсэн нэвтрүүлгээс бусад, өөрөөр хэлбэл 2.3 a), b), c), g)-д дурдсан нэвтрүүлгүүдийг дараах хэлбэрээр дамжуулна.

ALL STATIONS (нислэгийн хөдөлгөөний мэдээллийн нэвтрүүлэг хийж байгааг илтгэх зорилгоор заавал хэлэх шаардлагатай)

(агаарын хөлгийн дуудлага)
FLIGHT LEVEL (тоо) (эсхүл CLIMBING* TO FLIGHT LEVEL (тоо))
(чиглэл)
(ATS ROUTE) (эсхүл DIRECT FROM (байрлал) TO (байрлал))
POSITION (байрлал**) AT (цаг)
ESTIMATING (дараагийн илтгэх цэг, эсхүл тогтоогдсон нислэгийн замыг огтлох, эсхүл нэгдэж орох цэг) AT (цаг)
(агаарын хөлгийн дуудлага)
FLIGHT LEVEL (тоо) (чиглэл)
Зохиомол жишээ:
"ALL STATIONS AIRCHINA 501 FLIGHT LEVEL 340 NORTHWEST BOUND DIRECT FROM NIXAL TO DARNO ESTIMATING CROSSING ROUTE A573 AT THREE ONE AIRCHINA 501 FLIGHT LEVEL 340 NORTH WEST BOUND"

10.5.2 Нислэгийн түвшин өөрчлөхөөс өмнө, дараах нэвтрүүлэг (2.3 e)-д заасан)-ийг хийнэ:

ALL STATIONS
(агаарын хөлгийн дуудлага)
(чиглэл)
(ATS route) (or DIRECT FROM (байрлал) TO (байрлал))
LEAVING FLIGHT LEVEL (тоо) FOR FLIGHT LEVEL (тоо) AT (тоо болон цаг)

10.5.3 Энэ зүйлийн 2.4.4-т зааснаас бусад тохиолдолд, нислэгийн түвшин өөрчлөхдөө (2.3 f-д дурдсан) дараах нэвтрүүлгийг хийнэ:

ALL STATIONS
(агаарын хөлгийн дуудлага)
(чиглэл)
(ATS route) (or DIRECT FROM (байрлал) TO (байрлал))

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нууцын зөвшөөрөл
дээрх 26 А/108 дугаар тушаал

LEAVING FLIGHT LEVEL (тоо) NOW FOR FLIGHT LEVEL (тоо)

Дараах мэдээллийг үргэлжлүүлэн дамжуулна:
ALL STATIONS
(агаарын хөлгийн дуудлага)
MAINTAINING FLIGHT LEVEL (тоо)

10.5.4 Мөргөлдөх эрсдэлээс зайлсхийх зорилгоор нислэгийн түвшнийг түр хугацаагаар өөрчилж буй талаар мэдээлэхдээ дараах нэвтрүүлгийг хийнэ:

ALL STATIONS
(агаарын хөлгийн дуудлага)
LEAVING FLIGHT LEVEL (тоо) NOW FOR FLIGHT LEVEL (тоо)

Дараах мэдээллийг үргэлжлүүлэн нэн даруй дамжуулна:
ALL STATIONS
(агаарын хөлгийн дуудлага)
RETURNING TO FLIGHT LEVEL (тоо) NOW

10.6 Нэвтрүүлгийг хариу баталгаажуулах

Мөргөлдөж болзошгүй эрсдэл ажиглагдсанаас бусад тохиолдолд нэвтрүүлгийг хүлээн авснаа хариу баталгаажуулна.

11 Холбогдох үйл ажиллагааны зохицуулалт

11.1 Аяллын нислэгийн түвшнийг өөрчлөх

11.1.1 Мөргөлдөх эрсдэл болон цаг агаарын аюултай үзэгдлээс зайлсхийх, эсхүл бусад үйл ажиллагааны шалтгаанаас бусад тохиолдолд тогтоосон агаарын зайд агаарын хөлгийн аяллын нислэгийн түвшнийг өөрчлөхгүй.

11.1.2 Агаарын хөлөг аяллын нислэгийн түвшнийг өөрчлөхөөс өөр аргагүй үед бусад агаарын хөлөгт ил хараагаар харахад боломжтой болгох үүднээс өндөр өөрчлөх үедээ агаарын хөлгийн боломжит бүх гэрэлтүүлгийг асаасан байна.

11.2 Мөргөлдөхөөс зайлсхийх

Хэрэв өөр агаарын хөлгөөс мэдээлсэн нислэгийн хөдөлгөөний мэдээллийг хүлээн авсны дараа нисгэгч болзошгүй мөргөлдөх эрсдэлээс зайлсхийх зорилгоор яаралтай арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл, мөн үүнийг Конвенцын Хавсралт 2-т заасан давуу эрхийн (right-of-way) журмын дагуу хэрэгжүүлэх боломжгүй бол нисгэгч дараах арга хэмжээг авна:

a) өөр тохиромжтой маневрлах боломж байхгүй үед, яаралтай 150 м (500 ft) өндөр алдана;
b) бусад агаарын хөлөгт ил хараагаар харахад боломжтой болгох үүднээс агаарын хөлгийн боломжит бүх гэрэлтүүлгийг асаана;

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 11/08

c) авч хэрэгжүүлэх зөвлөмжийн арга хэмжээний талаарх нэвтрүүлэгт нэн даруй хариу өгнө;
d) авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар холбогдох НХҮ-ний давтамж дээр мэдэгдэнэ;
e) өмнөх нислэгийн түвшнээ аль болох хурдан буцаан эзэлж, энэ тухай холбогдох НХҮ-ний давтамж дээр мэдэгдэнэ.

Байрлалаа илтгэх хэвийн үеийн үйл ажиллагаа

11.3 Нислэгийн хөдөлгөөний мэдээллийн талаар нэвтрүүлэх буюу мэдээлэх, эсхүл хариу баталгаажуулахтай холбоотой авсан аливаа арга хэмжээг үл харгалзан байрлалаа илтгэх хэвийн үеийн үйл ажиллагааны журмыг нислэгийн бүхий л цаг хугацаанд дагаж мөрдөнө.

12 НИСЭХИЙН ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ

Нисэхийн мэдээллийн үйлчилгээ (AIS)

12.1 Улаанбаатар FIR-ийн нөөц үйл ажиллагааг дэмжих зорилгоор нисэхийн мэдээллийн үйлчилгээний нөөц төлөвлөгөөг боловсруулж, Улаанбаатар FIR-д NOTAM мэдээний үйлчилгээний тасралтгүй байдлыг хангана.

12.2 Хөрш зэргэлдээх нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагууд харилцан ажиллагааны гэрээний дагуу NOTAM мэдээний үйлчилгээгээр хангана.

Цаг уурын үйлчилгээ (MET)

12.3 Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Цаг уур, орчны шинжилгээний газар (NAMEM) нь Монгол Улсын нутаг дэвсгэрт цаг уурын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллага юм. Тус байгууллагын харьяа Нислэгийн цаг уурын төв нь Конвенцын Хавсралт 3 "Олон улсын агаарын навигацийн цаг уурын үйлчилгээ", мөн ICAO-ийн баримт бичиг Doc 9673 "The Air Navigation Plan -- Asia and Pacific Regions"-д заасан шаардлагуудын дагуу иргэний нисэхэд зориулсан дараах цаг уурын үйлчилгээг үзүүлдэг. Үүнд:

a) аэродромын ажиглалт ба мэдээ – орон нутгийн MET REPORT болон SPECIAL, мөн WMO кодчилсон METAR ба SPECI; METAR болон SPECI үйлчилгээг Ази/Номхон далайн үндсэн агаарын навигацийн төлөвлөгөө (Basic ANP)-ний АОР хүснэгт болон FASID TABLE MET 1A хүснэгтэд жагсаасан олон улсын бүх аэродомуудад үзүүлнэ.
b) FASID TABLE MET 1A-д заасан шаардлагуудын дагуу аэродромын цаг уурын урьдчилсан мэдээ (TAF).
c) Улаанбаатар FIR-д SIGMET үйлчилгээ; SIGMET мэдээг FASID TABLE MET 1B - WIII ба WAAA-д заасан цаг уурын ажиглалтын албад гаргана.
d) цаг уурын байгууллага болон НХҮ-ний нэгжүүдийн гэрээнд заасны дагуу НХҮ-ний нэгжүүд (TWR, APP, ACC)-д зориулсан мэдээлэл.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 #/108

e) Конвенцын Хавсралт 3-ын 9-р бүлэгт заасны дагуу нислэгийн өмнөх цаг агаарын мэдээллийн зааварчилгаа.

12.4 Монгол Улсын цаг уурын үйлчилгээ нь НХМ-ийн нөөц төлөвлөгөө идэвхжүүлэх нөхцөл байдал үүссэн тохиолдолд ч тасралтгүй үргэлжилнэ. Харин Улаанбаатар FIR-д НХҮ зогсоосон нөхцөлд нислэгийн үед нисэх багийг цаг уурын мэдээллээр шуурхай хангахад хүндрэл гарч болзошгүй. Энэ тохиолдолд Улаанбаатар FIR-тэй холбоотой сүүлийн үеийн цаг уурын мэдээллүүдийг хөрш улсын НХҮ байгууллагуудаар дамжуулан авах боломжийг бүрдүүлнэ. Түүнчлэн цаг уурын мэдээллүүд (TAF, METAR/SPECI)-ийг Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээлэл солилцох (MSS-Message Switch System) системийг ашиглан Дэлхийн цаг уурын байгууллагын холбооны сүлжээ (GTS-Global Telecommunication System, WIS2.0)-ээр Новосибирск, Токиогийн бүсийн мэдээллийн өгөгдлийн сан (RODB-Regional OPMET Data Banks)-д дамжуулж Москва, Вашингтон болон олон улсын дата төвүүдэд түгээнэ.

13 ЭРЭН ХАЙХ, АВРАН ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мэдээлэл дамжуулалт ба зохион байгуулалт

13.1 Монгол Улсын агаарын зайд онцгой байдалд орсон агаарын хөлгийн талаарх мэдээлэл цуглуулах, мэдээллийг тараах, мэдэгдэх, холбогдох зохицуулалтыг "ИНҮТ" ТӨХХК-ийн SAR үйл ажиллагааны мэдээлэл зохицуулах нэгж зохион байгуулна.

Утас (IDD): +976-71-281154
Факс: +976-71-281154
AFTN: ZMUBYCYX

13.2 Монгол Улсын Иргэний нисэхийн тухай хуулийн 25.2-т зааснаар, улсын онцгой комисс аюул тулгарсан агаарын хөлгийн SAR үйл ажиллагааг тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл бүртгэгч улсын эрх бүхий байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

13.3 SAR үйл ажиллагаанд ICAO-ийн дараах баримт бичгүүдийг мөрдөнө:

- Конвенцын Хавсралт 12 – Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа
- Олон улсын нисэхийн болон тэнгисийн SAR үйл ажиллагааны удирдамж (IAMSAR, ICAO-ийн баримт бичиг Doc 9731 3AN/958).

Хариуцлагын бүс

13.4 Онцгой байдлын ерөнхий газар нь Улаанбаатар FIR-д SAR үйл ажиллагааг хариуцна.

Үйлчилгээ

13.5 Агаарын хөлгийн осол болон түүнээс аврагдсан зорчигчдыг эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг зорчигчдын харьяалал үл харгалзан "ИНҮТ" ТӨХХК-ийн

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26.11.08

SAR үйл ажиллагааны мэдээлэл зохицуулах нэгж, Онцгой байдлын ерөнхий газрын нэгжүүд болон бусад холбогдох байгууллагууд хамтран гүйцэтгэнэ.

Эрэн хайх, авран туслах хэлэлцээр

13.6 Монгол Улс нь БНХАУ болон ОХУ-тай SAR үйл ажиллагааны хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулсан болно.

Агаарын хөлөгт ашиглах үйл ажиллагаа болон дохионууд

13.7 Ослын дуудлага, мэдээг хүлээн авсан агаарын хөлгийн даргын хэрхэн ажиллах талаарх заавар, журмыг Конвенцын Хавсралт 12-ын 5-р бүлэгт заасан байдаг.

Холбоо

13.8 Улаанбаатар FIR-д дамжуулсан буюу хүлээн авсан ослын мэдээг Конвенцын Хавсралт 10, Volume 2, 5.3-т заасны дагуу дамжуулна. SAR үйл ажиллагааны харилцаа холбоонд ICAO-ын баримт бичиг Doc 8400 "Abbreviations and Codes"-т заасан товчлол болон кодыг ашиглана.

13.9 ACC болон SAR үйл ажиллагааны мэдээлэл зохицуулах төв (цаашид ЭХАТАМЗТ гэх) нь 121.5 Мгц болон 5680 кГц давтамжуудад тасралтгүй хяналт тавьж ажиллана.

13.10 SAR үйл ажиллагааны туршид авран туслах агаарын хөлөг нь RESCUE дуудлага болон нэмэлт таних тэмдгүүд (ALFA, BRAVO, CHARLIE гэх мэт)-ийн аль алийг ашиглана. SAR үйл ажиллагаанд оролцож буй агаарын хөлгүүд нь 123.1 Мгц давтамжийг ашиглана.

13.11 ЭХАТАМЗТ нь COSPAS/SARSAT-аас мэдээлэл хүлээн авах цэг байна.

Эрэн хайх, авран туслах ажиллагаанд ашиглагдах дохио

13.12 SAR үйл ажиллагааны үед ашиглах дохио, тэмдгүүдийг Конвенцын Хавсралт 12-ын 5.8 болон уг баримт бичгийн нэмэлтэд зааснаар мөрдөнө.

13.13 Улаанбаатар FIR-д гарсан осол, зөрчлийн талаарх INCERFA, ALERFA болон DETRESFA мэдээг түгээхэд нөөц ажлын байр дэмжлэг үзүүлнэ.

13.14 Хэрэв Улаанбаатар ACC-ийн үйл ажиллагаа зогссон тохиолдолд, Улаанбаатар FIR-д гарсан онцгой нөхцөл болон осол зөрчилтэй холбоотой асуудлаар ЭХАТАМЗТ-тэй хамтран ажиллах үүргийг нөөц ажлын байр хүлээнэ. ТЗХ нь SAR мэдээллээр ЭХАТАМЗТ-ийг хангах зохих арга хэмжээ авна.

13.15 Хэрэв Улаанбаатар ACC болон нөөц ажлын байрны аль алийнх нь үйл ажиллагаа зогссон нөхцөлд Монгол Улсын нутаг дэвсгэрт SAR үйл ажиллагааг зохицуулах үүргийг Онцгой байдлын ерөнхий газар хүлээнэ.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26.11.08

ХАВСРАЛТ

Хавсралт А – Олон улсын байгууллагуудтай холбоо барих мэдээлэл

Хавсралт Б – Нислэгийн хөдөлгөөний менежментийн нөөц төлөвлөгөөний оролцогчдын холбоо барих мэдээлэл

Хавсралт В – NOTAM мэдээний загвар

Хавсралт Г – Монгол Улсын агаарын зайд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ тасарсан тохиолдолд ашиглах олон улсын нислэгийн замууд

Хавсралт Д – Нөөц нислэгийн замын зураг

Хавсралт Е – Нөөц давтамжууд

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ

ХАВСРАЛТ А – ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ

№	Хаяг	Утас	Факс	AFTN	И-мэйл
			THE RUSSIAN FEDERATION		
1	**Холбооны Агаарын Тээврийн Агентлаг** Хаяг: 125167, ГСП-3, Moscow, Leningrad Avenue, 37, Pavilion 2.	+7-495-6458555	+7-499-2315535		rusavia@scaa.ru
2	Красноярск ACC	+7-391-2526714		UNKLZRZX	
3	Новосибирск ACC	+7-383-3599031 +7-383-3190951		UNNTZRZX UNNTZDZX	
4	Иркутск ACC	+7-395-2522911	+7-395-2522921	UIIIZRZX	
			БНХАУ		
5	**БНХАУ-ын Иргэний нисэхийн удирдах газар, Нислэгийн хөдөлгөөний менежментийн товчоо** Хаяг: No.12 Dongsanhuanzhong Road, Chaoyang District, Beijing, The People's Republic of China.	TBD	TBD	TBD	webmaster@atmb.net.cn
6	Бээжин ACC	+86-10-64593674 +86-10-64593575	+86-10-64305502	ZBAAZRZX, ZBAAZPZX, ZBAAZQZX	
7	Ланжоу ACC	+86-931-8168332 +86-931-8166213 +86-931-8168338 +86-931-2146821	+86-931-8166344	ZLLLZRZX ZBBBZFPM	
8	Хөххот ACC	+86-471-4951900 +86-471-4941331 +86-471-3383229	+86-471-4941332	ZBHHZRZX; ZBHHZPZX; ZBAAZRZX	
9	Өрөмч ACC	+86-991-3809607 +86-991-3806023 +86-991-3809603 +86-991-3802107		ZWUQZQZX; ZBBBZFPM;	

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 я/108

10	Харбин ACC	+86-451-82895680 +86-451-84621874 +86-451-82895720 +86-451-58680334	+86-451-82895252	ZYHBZRZX, ZYHBZXZX, ZBBBZGZX	
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА					
12	**ICAO Ази, Номхон далайн бүсийн төв** Хаяг: ICAO 252/4 Vibhavadi-rangsit Road,Chatuchak, Bangkok 10900, Thailand Mail: P.O. Box 11 Samyaek Lathprao, Bangkok 10901, Thailand	+66-2-537-8189	+66-2-537-8199		apac@icao.int
13	**ICAO Ази, Номхон далайн бүсийн дэд төв (APAC RSO)** Хаяг: 1st floor, C Section, China Service Maison No.9 Erwei Road, Shunyi District, Beijng 100621, the People's Republic of China	+86-10-64557169	+86-106-4557164		hlinling@icao.int
14	**CANSO Ази, Номхон далайн бүсийн төв** Хаяг: Singapore Aviation Academy, Aviation Drive, Singapore, 499867	+65-6541-2006	+65-6543-4995		Nai.eng.chiang@canso.org
15	**IATA Төв оффис, Монреал хот** Хаяг: 800 Place Victoria PO Box 113 Montreal –H4Z 1M1 Quebec-Canada **Дэд оффис, Женев хот** Хаяг: 33, Route de l'Aeroport PO box 416 1215 Geneva -15 Airport Switzerland	+1-514-8740202 +41-22-7-702525	+1-514-8749632 +41-22-7983553		
16	**IFATCA** Хаяг: 1255 University Street Suite 408 Montreal Quebec H3B 3B6 Canada	+1-514-8667040	+1-514-8667612		evpasp@ifatca.org office@ifatca.org
17	**IFALPA** Хаяг: Head Office 485 rue McGil:, Bureau 700, Montreal, Quebec (Canada) H2Y 2H4	+1-514-4191191	+1-514-4191195		ifalpa@ifalpa.org

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 А/108

ХАВСРАЛТ Б – НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ МЕНЕЖМЕНТИЙН НӨӨЦ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ОРОЛЦОГЧДЫН ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ

1. ТӨВ ЗОХИЦУУЛАХ ХОРОО (ССС)-НЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ

№	Байгууллага	Хаяг	Утас	Факс	И-мэйл
1	**Батлан хамгаалах яам**	13340 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 51, Засгийн газрын VII байр	+976-51-264584	+976-51-264818	info@mod.gov.mn
2	**Зам, тээврийн яам**	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө -11, Засгийн газрын 13 дугаар байр	+976-51-263170 +976-11-312315	+976-11-312315	info@mrt.gov.mn
3	**Тагнуулын ерөнхий газар**	Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, жуулчны гудамж	+976-92-263017	+976-323017	
4	**Иргэний нисэхийн ерөнхий газар**	ИНЕГ, Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа, Улаанбаатар хот	+976-71-282229 +976-71-282064	+976-70049825	info@mcaa.gov.mn
5	**Онцгой байдлын ерөнхий газар**	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Партизаны гудамж-6, Онцгой байдлын ерөнхий газар	+976-51-263581 +976-11-262126		info@nema.gov.mn
6	**Цагдаагийн ерөнхий газар**	Самбуугийн гудамж-18, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Улаанбаатар хот, 15160, Монгол Улс	+976-70191000 +976-70191010 +976-70191020 +976-70191302	+976-70191025	info@police.gov.mn
7	**Цаг уур, орчны шинжилгээний газар**	Улаанбаатар-15160 Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,	+976-51-264152	+976-11-326611	info@namem.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ ЭХ ХУУЛЬ 26 А/108

		Жуулчны гудамж -5,Бага тойруу-3			
8	**Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал**	13340 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг; Энхтайваны өргөн чөлөө 51	+976-51-265614	+976-11-452933	gsmaf@mil.gov.mn
9	**"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК**	Хан-Уул дүүрэг, 21-р хороо Буянт-Ухаа, Улаанбаатар	+976-71-283111		ansd@ncac.mn
10	**"Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК**	41090 Төв аймаг, Сэргэлэн сум, Эрдэнэ-Уул 4-р баг, Тахилт толгой	+976-71287300		airportops@nubia-llc.mn

2. ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН БАГ (AOCG)-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ

№	Organization	Address	Telephone	Fax	E-mail
1	**"ИНҮТ" ТӨХХК-ийн дэд дарга**	Хан-Уул дүүрэг, 21-р хороо Буянт-Ухаа, Улаанбаатар	+976-71-285001		p_ganbold@ncac.mn
2	**"ИНҮТ" ТӨХХК-ийн Агаарын навигацийн үйлчилгээний газрын дарга**	Хан-Уул дүүрэг, 21-р хороо Буянт-Ухаа, Улаанбаатар	+976-99106790		bayartogtokh@ncac.mn
3	**"ИНҮТ" ТӨХХК-ийн Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны дарга**	Хан-Уул дүүрэг, 21-р хороо Буянт-Ухаа, Улаанбаатар	+976-71-281700		tuvshinbat.b@ncac.mn
4	**"ИНҮТ" ТӨХХК-ийн Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны дарга**	Хан-Уул дүүрэг, 21-р хороо Буянт-Ухаа, Улаанбаатар	+976-71-283131		ulemj@ncac.mn
5	**"ИНҮТ" ТӨХХК-ийн Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын албаны дарга**	Хан-Уул дүүрэг, 21-р хороо Буянт-Ухаа, Улаанбаатар	+976-71-285050		battugs.g@ncac.mn

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид ... 26 А/108

6	**“ИНҮТ” ТӨХХК-ийн Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны дарга**	Хан-Уул дүүрэг, 21-р хороо Буянт-Ухаа, Улаанбаатар	+976-71-285086		batbayar.t@ncac.mn
7	**Нислэгийн цаг уурын төвийн дарга**	Хан-Уул дүүрэг, 21-р хороо Буянт-Ухаа, Улаанбаатар	+976-71-287279 +976-71-283039	+976-70049869	amc@namem.gov.mn
8	**“ИНҮТ” ТӨХХК-ийн Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны Бүсийн удирдлагын үйлчилгээний хэсгийн ерөнхий нислэгийн хөдөлгөөний удирдагч**	Хан-Уул дүүрэг, 21-р хороо Буянт-Ухаа, Улаанбаатар	+976-71-281747		byambadorj.d@ncac.mn

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 11/108

ХАВСРАЛТ В – NOTAM МЭДЭЭНИЙ ЗАГВАР

a) AVOIDANCE OF AIRSPACE

NOTAM.....

DUE TO DISRUPTION OF ATS IN ULAANBAATAR FIR ALL ACFT ARE ADVISED TO AVOID THE FIR.

b) AIRSPACE AVAILABLE LIMITED ATS

NOTAM.....

DUE TO ANTICIPATED DISRUPTION OF ATS IN ULAANBAATAR FIR ALL ACFT ARE ADVISED THAT THERE WILL BE LIMITED ATS. PILOTS MAY EXPIERENCE DLA AND OVERFLIGHTS MAY CONSIDER AVOIDING THE AIRSPACE

c) CONTINGENCY PLAN ACTIVATED

NOTAM.....

DUE TO DISRUPTION OF ATS IN ULAANBAATAR FIR ALL ACFT ARE ADVISED THAT UB FIR CONTINGENCY PLAN FOR ACFT INTENDING TO OVERFLY ULAANBAATAR FIR IS IN EFFECT. FLIGHT PLANNING MUST BE IN ACCORDANCE WITH THE CONTINGENCY ROUTES LISTED AND FL ASSIGNMENT. PILOTS MUST STRICTLY ADHERE TO THE CONTINGENCY PROCEDURES. ONLY APPROVED INTERNATIONAL FLIGHTS ARE PERMITTED TO OVERFLY MONGOLIAN AIRPSACE.

d) NON ADHERENCE TO THE CONTINGENCY PLAN

NOTAM.....

OPERATORS NOT ABLE TO ADHERE TO THE CONTINGENCY PLAN SHALL AVOID ULAANBAATAR FIR.

e) RESUME TO NORMAL OPERATION

NOTAM .....

MONGOLIAN CONTINGENCY – RECOVERY TO NORMAL OPERATIONS



TRANSITION TO NORMAL OPERATIONS IN THE ULAANBAATAR FIR WILL COMMENCE AT [TIME] UTC

ALL FLIGHTS OPERATING IN THE ULAANBAATAR FIR PRIOR TO [TIME] UTC SHALL FILE FLIGHT PLAN AND OPERATE IN ACCORDANCE WITH THE REQUIREMENTS PROMULGATED IN PART ENR 3.5 MONGOLIAN AIP.

FLIGHTS PLANNED TO OPERATE IN THE ULAANBAATAR FIR AT OR AFTER [TIME] UTC SHALL FILE FLIGHT PLAN VIA STANDARD NON-CONTINGENCY ATS ROUTES AS PUBLISHED IN MONGOLIAN AIP. LEVEL AND ROUTE RESTRICTIONS MAY BE TACTICALLY APPLIED DURING THE TRANSITION TO NORMAL OPERATIONS. OPERATORS SHOULD CONSIDER THE CARRIAGE OF ADDITIONAL FUEL.

FLIGHTS OPERATING WITHIN THE ULAANBAATAR FIR SHALL NOT SUBMIT IN-FLIGHT RE-FILE OF FLIGHT PLANS OR REQUEST TACTICAL RE-ROUTING TO NORMAL ROUTES OR TRACK SHORTENING, EXCEPT ONLY IN CASES OF EMERGENCY OR DIVERSION FOR LANDING AT AERODROMES OTHER THAN FLIGHT PLANNED.

ATC MAY TACTICALLY OFFER IMPROVED ROUTES OR FLIGHT LEVELS WHERE AVAILABLE.

FLIGHT CREWS SHOULD BE AWARE THAT THERE MAY BE MIXED CONTINGENCY ROUTE/LEVEL AND NON-CONTINGENCY ROUTE/LEVEL OPERATIONS IN THEIR VICINITY DURING THE TRANSITION TO NORMAL OPERATIONS.

f) TIBA PROCEDURES IN EFFECT

NOTAM .....

DUE TO DISRUPTION OF ATS IN ULAANBAATAR FIR, TRAFFIC INFORMATION BROADCAST BY AIRCRAFT (TIBA) PROCEDURES ARE IN EFFECT ON FREQ 126.3 MHz (135.3MHz, 128.4MHz). ALL ACFT SHALL MAINTAIN A LISTENING WATCH AND BROADCAST POSITION INFORMATION.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЗХ ХУВЬ
26 11/08

ХАВСРАЛТ Г – МОНГОЛ УЛСЫН АГААРЫН ЗАЙД НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ТАСАРСАН ТОХИОЛДОЛД АШИГЛАХ ОЛОН УЛСЫН НИСЛЭГИЙН ЗАМУУД

Нөөц нислэгийн зам (CRUB)	НХҮ-тэй нислэгийн зам	Чиглэл	Нислэгийн түвшин	ACCs	Холбооны шугам
CRUB-1	Y520 SERNA-NONAR-POLHO	Урд зүг	FL391, FL331	Бээжин ACC	VHF 134.25
CRUB-2	Y746 DARNO-BUTIV-UBSUN-BEGVO-LEDED-ANGID-MASMU-ENGUG-NIXAL	Урд зүг	FL391, FL331	Бээжин ACC	VHF 134.25
CRUB-3	Y962 MORIT-SADUM-IGOMA-SUNAP-IDVOG-OVMAG-OMDOT-NIGOR	Хойд зүг	FL361, FL301	Красноярск ACC	VHF 133.1
CRUB-4	A575-R372 INTIK-SND-ANIKU-TOROV-UDA-AMUTA	Хойд зүг	FL381, FL341	Иркутск ACC	VHF 134.1

*** Хөрш зэргэлдээх НХУ-ын нэгжтэй байгуулсан харилцан ажиллагааны гэрээ.**

1. VSAT Hub-1 in Murun, RCAG-4 (2 pieces for 2 channels), VSAT-Remote for each Munkh-Ulziit, and Sainshand and a VHF set for Munkh-Ulziit.

2. Optic cable line of Murun-Munkh-Ulziit-Sainshand to be fully connected to Unitelecom LLC and Railcom optic cable network.

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 11/108

ХАВСРАЛТ Д – НӨӨЦ НИСЛЭГИЙН ЗАМЫН ЗУРАГ



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Д/108

ХАВСРАЛТ Е – НӨӨЦ ДАВТАМЖ

Нөөц нислэгийн зам (CRUB)	АСС	Чиглэл	Нөөц давтамж
CRUB-1	Улаанбаатар	Урд зүг	Y520 VHF135.3 (SERNA - NONAR) VHF128.3 (NONAR - POLHO) HF-5680
CRUB-2	Улаанбаатар	Урд зүг	Y746 VHF135.3 (DARNO - ANGID) VHF128.3 (ANGID - NIXAL) HF-5680
CRUB-3	Улаанбаатар	Хойд зүг	Y962 VHF128.3 (MORIT - SADUM) VHF126.3 (SADUM - NIGOR) HF-5680
CRUB-4	Улаанбаатар	Хойд зүг	A575-R372 VHF128.3 (INTIK - ANIKU) VHF135.3 (ANIKU - AMUTA) HF-5680

Тайлбар: Нисгэгч нь Хавсралт Е-д заасан "Нөөц давтамж"-ийн дагуу НХУ-ын сектор хооронд NONAR, ANGID, SADUM, ANIKU гэсэн удирдлага шилжүүлэх цэгүүд дээр давтамж солихыг анхаарна уу.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
26 A/108